



КАНАД УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ Йоркийн их сургуулийн эсрэг Канадын Зохиогчийн эрхийн лицензийн агентлаг (Аксессийн зохиогчийн эрх) тухай маргаан

САНАМЖ: Энэхүү хураангуй нь гагцхүү олон нийтэд мэдээлэл болгох зорилготой бөгөөд хураангуй нь гадаадын хяналтын шатны шүүхийн шийдвэр болно.

Улсын Дээд шүүх зохиогчийн эрхийн тариф нь Йоркийн их сургуульд хамаарахгүй байхаар шийдвэрлэсэн.

1994-2010 он хүртэл Йоркийн их сургууль ("Йорк") Аксесс зохиогчийн эрхийн нийгэмлэгтэй лицензийн гэрээтэй байсан бөгөөд уг гэрээнд Йоркийн профессоруудад Аксессийн цуглуулгад хэвлэгдсэн бүтээлүүдийг хуулбарлах боломжийг роялти төлбөртэйгөөр олгохоор тохиролцсон байна. /Роялти-лицензээр худалдан авсан ноу-хаугийн төлбөр/

Аксесс нь тухайн бүтээлүүдийн зохиогчийн эрхийг эзэмшигч биш бөгөөд зохиогч, хэвлэн нийтлэгчдийн нэрийн өмнөөс зохиогчийн эрхийг хамгаалах хамтын нийгэмлэг юм.

2010 онд роялти нь өдрийн ангийн нэг оюутны жилийн хураамж 3,38 ам. доллар, мөн оюутнуудад худалдах, хүртээх зорилго бүхий курсын багцад хуулсан хуудас тутмын 0,10 доллароос бүрддэг байв.

2010 онд Йорк, Аксесс нар нь гэрээг шинэчлэхээр хэлэлцээр хийж байсан бөгөөд лицензийн хугацаа дуусахад Аксесс Канадын "Зохиогчийн эрхийн зөвлөл"-өөс түр тариф тогтоох хүсэлт гаргасан.

Канадын "Зохиогчийн эрхийн зөвлөл" нь зохиогчийн эрхийн нийгэмлэгт бүртгэгдсэн тохиолдолд зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлийн ашиглалтад төлөх роялтийг тогтоодог байгууллага юм.

Түр тариф 2011 оны 1-р сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд Йоркийн их сургууль 2011 оны 7 дугаар сар хүртэл роялти ашигласны төлбөрөө төлөөд дахин төлөхөө зогсоосон.

Йоркийн их сургуульд түр тариф хамаарахгүй бөгөөд Зохиогчийн эрхийн тухай хуулийн "шударга ашиглалт" заалтын дагуу Аксессийн цуглуулгаас ямарваа нэгэн төлбөргүйгээр хуулбарлах эрхтэй тул гэж мэдэгдэв. Тус заалт нь нийтийн ашиг сонирхлын төлөө зөвшөөрөл шаардагдахгүйгээр бүтээлийг хуулбарлахыг зөвшөөрдөг.

Йоркийн их сургууль үүнд судалгаа, боловсролын үйл ажиллагаа хамаарна гэж тайлбарласан.

2013 онд Аксесс компани Холбооны шүүхээс түр тарифыг хэрэгжүүлэхийг хүссэн бөгөөд Аксесс Йоркийн хуулбарлалтыг лицензгүй бас шударга ашиглалтын заалтаар хамгаалагдаагүй гэж маргажээ. Харин Йоркийн их сургууль хуулбарууд нь уг заалтаар хамгаалагдсан гэж маргасан.

Холбооны шүүх Аксессийн талд шийдвэр гаргасан. Дараа нь Йоркийн их сургууль Холбооны давж заалдах шатны шүүхэд хандсан бөгөөд энэ нь Йоркийн их сургуулийн тарифын хэрэгжилтийн талаарх давж заалдах гомдлыг



зөвшөөрсөн боловч шударга ашиглалтын асуудлаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосон.

Үүний дараа хоёр тал Канадын Дээд шүүхэд хандсан боловч Дээд шүүх гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.

“Зохиогчийн эрхийн зөвлөл”-өөс баталсан тариф нь хэрэглэгчдийн хувьд заавал дагаж мөрдөх шаардлагагүй.

Дээд шүүх санал нэгтгэйгээр тарифыг заавал дагаж мөрдөх шаардлагагүй бөгөөд Йоркийн их сургууль үүнийг төлөх шаардлагагүй гэж дүгнэсэн.

Шүүгчид Йоркийн их сургууль гэрээгээ биелүүлэхгүй гэж шийдсэн тохиолдолд Зохиогчийн эрхийн тухай хууль нь Аксес-д Йоркийн их сургуулийн эсрэг лиценз ашигласны төлбөрийг түр болон эцсийн тарифаар ногдуулах эрх олгохгүй гэж үзсэн.

Хэрэглэгчдийг хамгаалах

Зохиогчийн эрхийн тухай хуулийн хамтын захиргааны заалтууд нь Йоркийн их сургууль зэрэг хэрэглэгчдийг хамгаалах зорилготой юм. Тухайлбал, эдгээр заалтууд нь лицензийн тусгай зөвшөөрлийн төлбөрийн дээд хэмжээг зохицуулдаг. Гэхдээ хамтын нийгэмлэгийг хүсээгүй хэрэглэгчдийг хүчлэхийг зөвшөөрдөггүй.

Энэ нь тэдний хамгаалагдсан зорилгод сөргөөр нөлөөлнө. Хэрэглэгчид лицензийг хүлээн авах эсэхээ үргэлж сонгох боломжтой байна.

Зөрчлийн хэрэг биш

Хэрэв хүмүүс лицензийг хүлээн авсан ч лиценз ашигласны төлбөрөө төлөөгүй бол төлбөр төлөөгүйдээ хариуцлага хүлээнэ. Тэд лицензийг хүлээн аваагүй тохиолдолд төлбөр төлөөгүйн төлөө бус харин зохиогчийн эрхийн зөрчилд хариуцлага хүлээнэ.

Энэ тохиолдолд Йоркийн их сургууль лицензийг хүлээн аваагүй тул төлбөр төлөөгүйдээ хариуцлага хүлээхгүй.

Шүүхээс Аксес зохиогчийн эрх зөрчсөн талаарх нэхэмжлэл гаргах эрхгүй тул энэ хэргийг зохиогчийн эрх зөрчсөн маргаан биш гэж үзсэн байна.

Тус нэхэмжлэлийг гаргах эрх бүхий этгээд нь зохиогчийн эрхийг эзэмшдэг зохиогчид болон нийтлэгчид юм. Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдүүд байхгүй учир шүүх шударга ашиглалтын асуудлыг шийдвэрлэхээс татгалзсан.

-oOo-